



МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
САН

ЖИЛИЙН
ТАЙЛАН

**БИД
ТҮҮЧЭЭЛЭХ
ЁСТОЙ**

**МАНДАЛ
ИРЭЭДҮЙН
ӨСӨЛТ**



Агуулга

- МЭНДЧИЛГЭЭ
 - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗАСАГЛАЛ
 - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
 - САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ
 - ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ
 - САНД ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ХОМК, КАСТОДИАН, АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА
 - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД
-

МЭНДЧИЛГЭЭ

Та бид хамтран монголын хамгийн том Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сангаа үүсгэн байгуулж байсан бол өдгөө 9,000 хөрөнгө оруулагчтай өнөр өтгөн айл болжээ.

Системд нөлөө бүхий банкнуудаас 2022 оны 09 сард Төрийн банк нь нээлттэй хувьцаат компани болох ажлыг түүчээлэн эхлүүлсэн бол 2022 оны 11 сард Голомт банкны анхдагч зах зээлийн захиалга мөн амжилттай биелэв.

Эндээс Банкны IPO нь гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад ихээхэн эрэлттэй, нөгөө талаас хөрвөх чадвар сайтай гэж дүгнэж болох юм.

Ийнхүү Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан нь Төрийн банк, Голомт банканд стратегийн түвшинд хөрөнгө оруулалт хийснээр сангийн хөрөнгө оруулагчид маань Банкны эзэд болсон.

2023 оны 06 сарын 30-ны өдөрт багтаан ХААН, ХасБанк, Худалдаа Хөгжлийн Банк нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үүрэгтэй бөгөөд сан нь хүлээгдэж буй банкнуудын IPO-д идэвхтэй оролцох болно.

Улмаар банкны IPO дуусахад та бид хөрөнгө оруулалтын сангаар дамжин банкны эзэн болж, хөрөнгө оруулалтаа урт хугацаанд өсгөх боломж бүрдэх юм.

Энэхүү үйл хэрэгт хамт байж, бидэнтэй цуг түүхийн нэгээхэн хэсгийг бичилцэж буй танд баярлалаа. Та бид хамтдаа ирээдүйд илүү сайн сайхан зүйлсийг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Олны хүч, Оломгүй Далай!



G. Ganзориг

Г.ГАНЗОРИГ
Сангийн менежер

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗАСАГЛАЛ

Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь санг удирддаг. Сангийн ТУЗ нь хамтын удирдлага бүхий бүтэцтэй бөгөөд тогтмол хуралдаж сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, санг үр ашигтай шийдвэр гаргах улмаар үйл ажиллагааг хянах, хөрөнгө оруулалтын стратегийг тодорхойлох үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллав. Сангийн ТУЗ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба ТУЗ-ийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүйгээр, хараат бусаар Сангийн нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажилладаг. Сангийн ТУЗ-ийн гишүүд нь банк, даатгал, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбарт ажиллаж байсан туршлага, чадвартай болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Ө.Ганзориг	ТУЗ-ийн дарга
Н.Монсор	ТУЗ-ийн гишүүн
Ч.Даваадаш	ТУЗ-ийн гишүүн
Ц.Батсүх	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ч.Анхбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, ЭРСДЭЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сангийн Хөрөнгө оруулалтын бодлого нь “Income investing” буюу “тогтмол орлого” болон “growth investing” буюу “хөрөнгийг өсгөх” гэсэн хосолмол аргад суурилдаг. Сан нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хөрөнгө оруулалтуудыг эрсдэлийн зохих түвшинд барин өндөр өгөөж олох зорилгоор багцаа бүрдүүлдэг ба хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд ажиллаж байна. Үүний дагуу бид багцын дийлэнх хувийг хувьцаанд болон тогтмол орлоготой үнэт цаасанд, үлдсэн хэсгийг мөнгөний захын хэрэгсэлд хөрөнгө оруулаад байна.

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх тул нийгэм эдийн засаг, санхүү болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг удирдах шаардлага тулгарна. Иймд компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлдэг. Тухайлбал, ажилтан нь хэлтэс болон сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тогтмол тодорхойлох, үнэлэх, бууруулах нь эрсдэлийг оновчтой удирдах гол аргачлалын нэг юм. Эрсдэлийг удирдах доорх бүтцээр Хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) нь сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэг. Үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийн удирдлагын талаарх ойлголтыг нэвтрүүлэхийн сацуу ажилтан бүр энэ талын мэдлэгээ тогтмол

дээшлүүлж ажиллахыг эрхэмлэдэг. Эрсдэлийн бодлогын хүрээнд дараах эрсдэлүүдийг түлхүүр болгон тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэхдээ багцын эрсдэлийг тооцож, тархаан байршуулдаг. Хөрөнгө оруулалтын судалгаанд эрсдэлийн үнэлгээг заавал тооцдог ба эрсдэлийн удирдлагын олон жилийн туршлагатай баг хамт олон хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргадаг.

Зах зээлийн болон сангийн үйл ажиллагааны эрсдэл

Сангийн үйл ажиллагаанд хүний нөөц, техник технологи, дотоод дүрэм журам болон дотоод гадаад зах зээлийн эрсдэлүүд тулгардаг. Тухайлбал, ажилтнаас хамаарах үйл ажиллагааны алдаа, технологийн доголдол болон хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлүүд багтдаг. ХОМК нь хүний нөөцийн эргэц багатай бөгөөд удирдлагын багаа нь олон жилийн туршлагатай мэргэжилтнүүдээс бүрдүүлсэн нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах түлхүүр болж байна.

Сангийн удирдаж буй хөрөнгийн үнэлгээ эдийн засаг, улс төр, санхүү болон нийгмийн эрүүл мэндтэй холбоотой (халдварт өвчин, цар тахал гэх мэт) эсхүл зах зээлийн хүлээгдээгүй гэнэтийн үйл явдлуудаас шалтгаалан хөрөнгө оруулалтын үнэ цэн өсөх, буурах зэргээр хэлбэлзэж болно. Дээрх хүчин зүйлүүдээс шалтгаалсан гэнэтийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, төсөөлөх нь хүнд сорилт байдаг. ХОМК нь нийгэм эдийн засгийн өдөр тутам хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тохируулан богино хугацаанд хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны эрсдэлийг удирдах хүрээнд судалгаа шинжилгээнд суурилсан оновчтой шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

Тодруулбал:

Хүүгийн түвшний эрсдэл:

Зах зээл дэх хүүгийн түвшин өөрчлөгдөх нь Сангийн хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшинд нөлөөлнө. Иймд хүүгийн түвшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, тогтвортой үйл ажиллагаатай, хөрвөх чадвар өндөртэй банк, үнэт цаас гаргагчтай хамтран ажилладаг.

Инфляцын эрсдэл:

Сангийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаас олох өгөөж нь ирээдүйн инфляцын түвшин, мөнгөний үнэ цэнийн утгаас хамааран бодит утгаараа төлөвлөсөн хэмжээнээс бага байх эрсдэл бий. Инфляцын өсөлт нь эдийн засгийн бусад хүчин зүйлст нөлөөлөх ба үнэт цаасны бодит үнэ цэнд нөлөөлнө. Сан нь инфляц, эдийн засгийн загварын таамаглал ашиглан ирээдүйн инфляцын түвшинг тооцдог.

Валютын ханшийн эрсдэл:

Зах зээлийн тодорхой бус байдал нь ханшийн хэлбэлзлийг бий болгож, улмаар энэхүү эрсдэл нь төгрөгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг бууруулж байдаг. Иймд валютын ханшийг таамаглаж, энэхүү эрсдэлийг удирдан ажиллаж байна.

САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛ


Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК /цаашид “Сан” гэх/-ийн нийт хөрөнгө 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 55.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Цэвэр активын үнэлгээ, нэгж эрхийн үнэ

Цэвэр хөрөнгийн үнэ цэн	Нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэ цэн
55.7 тэрбум ₮	1,114₮


График 1 Нэгж эрхийн үнэ | төгрөгөөр



Цэвэр хөрөнгийн үнэ цэн нь нэгж эрхийн бодит үнэлгээг тодорхойлох үнэлгээний аргачлал юм. Сангийн хувьд тус үзүүлэлт өссөөр байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,114 төгрөг байна.

САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ


График 2 Хөрөнгө оруулалтын багцын ангилал | валютаар



2022 оны 12-р сарын 31-ний байдлаар байдлаарх хөрөнгө оруулалтын багцыг валютаар нь авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын 78 хувийг төгрөг, 22 хувийг ам.доллаар хийжээ.

Сан нь тогтмол өгөөж бүхий өрийн хэрэгсэл, мөнгөний захын хэрэгсэл, хувьцаанд хөрөнгө оруулдаг бөгөөд сангийн хөрөнгө оруулалтын багц дахь хэрэгслүүдийн өгөөж 20.9 хувь хүртэл хэлбэлзэж байна.

График 3 Хөрөнгө оруулалтын багцын ангилал | хувиар



Хувьцаа

- Голомт банк
- Төрийн банк
- Апу - бусад хувьцааны багц

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

- Бэрс Финанс
- Омни Актив
- Симпл ХБҮЦ

Компанийн бонд


- Инвескор бонд
- Лэнд бонд

Засгийн газрын бонд

- Хуралдай

Мөнгөний захын хэрэгсэл

График 4 Хөрөнгө оруулалтын өгөөжийн гүйцэтгэл | хувиар



Онцлох хөрөнгө оруулалтууд:

- Засгийн газрын үнэт цаас нь эрсдэл бага, хүүгийн болон ханшийн зөрүүний орлого бүхий хөрөнгө оруулалт гэдгээрээ давуу талтай байдаг. Сан нь 2022 оны 2 дугаар улиралд Засгийн газрын "Хуралдай" бондод хөрөнгө оруулалт хийсэн ба тус хөрөнгө оруулалт нь 20.9 хувийн өгөөжийн гүйцэтгэлтэй байна.
- 2022 оны тайлант жилд системийн нөлөө бүхий банк болох Төрийн банк болон Голомт банкны IPO-д оролцож хувьцаа эзэмшигч болсон билээ. Хөрөнгө оруулалтын хугацаанд Төрийн банкны хувьцаа 9.9 хувь, Голомт банкны хувьцаа -1.3 хувийн өгөөжтэй байна. Төрийн банк нь нэгж хувьцаанд 63.68 төгрөг, Голомт банк нь 50 төгрөгөөр тооцон ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.
- “АПУ” ХК-ийн хувьцаанд 2022 оны 3 дугаар улиралд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд тус хөрөнгө оруулалт нь 16.8 хувийн өгөөжтэй байна. Ногдол ашгийн тухайд нэгж хувьцаанд 44 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.

ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ

Банканд стратегийн түвшинд хөрөнгө оруулалт хийв

Системд нөлөө бүхий банкнуудаас 2022 оны 09 сард Төрийн банк нь нээлттэй хувьцаат компани болох ажлыг түүчээлэн эхлүүлсэн бол 2022 оны 11 сард Голомт банкны анхдагч зах зээлийн захиалга нь амжилттай биелэв. Энэ нь банкны IPO гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад ихээхэн эрэлттэй, нөгөө талаас хөрвөх чадвар сайтайг илтгэнэ.

Ийнхүү Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан нь Төрийн банк, Голомт банканд стратегийн түвшинд хөрөнгө оруулалт хийснээр сангийн хөрөнгө оруулагчид маань Банкны эзэд болсон.

Хөрөнгө оруулалтын сангийн орлогыг албан татвараас чөлөөлөхтэй холбоотой хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдав

Монгол улсын хувьд хөрөнгө оруулалтын орлогыг 2021 онтой харьцуулахад 7 хувиар буурсан бөгөөд үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт голлох нөлөө үзүүлжээ.

Ингээд эдийн засгийн өсөлтийг сэргээх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1.15-д “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлнө” гэсэн зохицуулалтыг УИХ-с 2022 оны 11 сард баталж тус нэмэлт өөрчлөлт нь 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Мэргэжлийн судалгаа шинжилгээ, мэдээллээр хангав

Мандал Ассет Менежмент-н хөрөнгө оруулалтын шинжээч, эдийн засагчид улирал тутам Банкны салбарын тойм, Макро эдийн засгийн тоймыг бэлтгэн 2022 оны байдлаар сангийн 9,000 хөрөнгө оруулагч, социал сувгаар 20,000 гаруй хүнд хүрчээ. Мөн бодлогын түвшинд журмын төслүүдэд шаардлагатай судалгааг хийж саналаа хүргүүлэн ажиллаж байна.

Сангийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулав

Харилцагчийн төв нь хөрөнгө оруулагчдад үнэ төлбөргүй санхүүгийн зөвлөгөө өгөх, тэдэнд тулгарсан аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Хөрөнгө оруулагчийн зүгээс Мандал Ирээдүйн Өсөлт сангийн нээлттэй мэдээлэлд хандах, түүнтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав. Үүнд:

- Сангийн хөрөнгө оруулагч нь хувийн мэдээллээ ашиглан www.mandalasset.mn -д нэвтэрснээр, сангийн хөрөнгө оруулалтын багцын ангилал, цэвэр хөрөнгийн үнэ цэнийг мэдэх юм.
- Мандал Ирээдүйн өсөлт ХОС сангийн хөрөнгө оруулагчийн хаалттай социал групп-д нэгдсэнээр, сангийн үйл ажиллагааны тайланг тухай бүр авах боломжтой.
- 7575-9911 утсаар ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд



холбогдохоос гадна оффис дээр уулзалт хийх байдлаар шууд мэдээлэл авч болно. 2022 оны байдлаар давтагдсан тоогоор 4,000 хөрөнгө оруулагчдад сангийн үйл ажиллагааны тухай мэдээллийг хүргэжээ.

Санхүүгийн боловсролыг дэмжив

Мандал-н философи нь бусдад өгөх сэтгэл дээр суурилдаг. Иймдээ ч, Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС-н ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг нь мөнгө өсгөх шалгарсан аргуудыг багтаасан Мөнгөний менежмент номыг хөрөнгө оруулагч нартаа зориулан гаргасан юм. Уг номд мөнгийг хэрхэн хуримтлуулж, зөв хөрөнгө оруулалт хийх замаар мөнгөө өсгөх аргуудыг тусгаж өгсөн байна.

Мөн онлайн сургалтыг нийт 10 удаа зохион байгуулж, нийт 5,000 гаруй хүн хамрагджээ. Уг сургалтаар Макро эдийн засгийн тойм, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн судалгаа, долларын ханш, хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэх зэрэг хөрөнгө оруулагч нарт шаардлагатай мэдээллээр ханган ажиллав.



Монголын хамгийн том Эрсдэлийн Форум 13 дах жилдээ амжилттай зохион байгуулагдав

Мандал Эрсдэлийн Форум нь улс орны эдийн засаг, нийгэм, бизнесийн салбарт тулгараад буй эрсдэлүүдийг судалж илрүүлэх, тэдгээрийг удирдах арга замуудыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэлэлцэн боловсруулдаг. Түүнчлэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад бодит хувь нэмэр оруулдаг өндөр ач холбогдолтой арга хэмжээ гэдгээрээ онцлог юм.

Тус форумд Мандал Ассет Менежмент-н Гүйцэтгэх захирал, эдийн засагч Г.Ганзориг “Дэлхийн эдийн засгийн хямрал” сэдвийн хүрээнд илтгэл танилцуулав.

Хувь хүн, институтийн түвшинд эдийн засгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах түүлсийг хуваалцсан нь ихээхэн өгөөжтэй байсан талаар оролцогч, хөрөнгө оруулагчид дурдаж байв.

Мандал-н зүгээс зохион байгуулагдаж буй бүхий л форум, арга хэмжээнд сангийн хөрөнгө оруулагчдаа урин оролцуулж, нийгэм эдийн засгийн төлөв байдал, цаашдын хандлагын талаарх мэдээллийг нэн тэргүүнд өгөхийг хичээдэг болно.



GLOBAL BANKING & FINANCE AWARDS® - 2022 - Award Winners

Award Category	Award Title	Award Winning Company	Country / Region
Banking & Finance Technology Awards	Best Banking Technology Implementation UK 2022	Lloyds Banking Group & Publicis Sapient	United Kingdom
Banking & Finance Technology Awards	Best Banking Technology Project UK 2022	Lloyds Banking Group & Publicis Sapient	United Kingdom

Fund & Asset management Awards Best Asset Management Company Mongolia 2022 Mandal Asset management Mongolia

Award Category	Award Title	Award Winning Company	Country / Region
Fund & Asset Management Awards	Islamic Asset Management Company of the Year 2022	KT Portfolio Asset Management Company	Turkey
Fund & Asset Management Awards	Most Innovative Investment Product (KFCMEGA) Thailand 2022	Krungsi Asset Management Co Ltd	Thailand
Fund & Asset Management Awards	Pension Fund Manager of the Year Thailand 2022	Krungsi Asset Management Co Ltd	Thailand
Fund & Asset Management Awards	Pension Fund Provider/ Manager Of the Year Brazil 2022	BNP Paribas Asset Management Brazil	Brazil
Fund & Asset Management Leadership Awards	Asset Management CEO of the Year Italy 2022	Dr. Ugo Loeser, Arca Fondi SGR S.p.A.	Italy
Fund & Asset Management Product & Process Awards	Best Fund Management Product (Al Wataniya Investment Fund) MENA 2022	National Investments Company	Kuwait
Fund & Asset Management Product / Process Awards	Best Mutual Fund (Atlântico Liquidez) Angola 2022	Hemera Capital Partners PLC	Angola
Fund & Asset Management Product / Process Awards	Best Real Estate Fund Angola 2022	Hemera Capital Partners PLC	Angola



САНД ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ХОМК, КАСТОДИАН, АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ: “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК

“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК /цаашид ХОМК гэх/ нь 2011 оны 7 сарын 19-нд үүсгэн байгуулагдаж, 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд хөрөнгө оруулалтын менежмент, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сантай 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдаж байна.

ХОМК-ийн нэр	“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК
Байгуулагдсан огноо	2012 он
Тусгай зөвшөөрөл	Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа
Удирдаж буй бусад сангууд	“Мандал Праявит Экүити Хувийн ХОС” ХХК “Мандал Хуримтлал Хамтын ХОС” ХХК
Холбоо барих	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамьян-Гүний гудамж, Меру тауэр-602 тоот Утас: 75759911 И-мэйл: support@mandalasset.mn

ХОМК нь удирдаж буй хөрөнгийн хэмжээ, хөрөнгө оруулагчдын тоо, удирдаж буй хөрөнгө оруулалтын сангуудын тоогоор хамгийн том хөрөнгө оруулалтын компани юм. Мөн дэлхийн банк санхүүгийн зах зээлийн томоохон төлөөлөгчдийн нэг болох “Global Banking and Finance Review” санхүүгийн сэтгүүлээс жил бүр зохион байгуулдаг “Global Banking and Finance Review Award-2022” шалгаруулалтад “Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК нь тэргүүлж “Монгол Улсын Шилдэг Хөрөнгө Оруулалтын Менежментийн Компани” -аар Монгол Улсаас анх удаа шалгарсан.

Менежментийн компанийн итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан

ХОМК нь одоогоор гурван төрлийн сангаар дамжуулан нийт 85.2 тэрбум төгрөгийг удирдаж буй Монголын тэргүүлэх хөрөнгө удирдлагын компани юм. Үүнээс 50 тэрбум төгрөгийг “Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК (цаашид “Сан” гэх)- аар дамжуулан татан төвлөрүүлж, хууль, дүрэм журамд заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгөө байршуулан ажиллаж байна.

АУДИТЫН БАЙГУУЛЛАГА “Мүүрь Аудит” ХХК

“Мүүрь Аудит” ХХК нь 2008 онд Од Бүртгэл Аудит ХХК нэртэйгээр байгуулагдсан. Фирм нь аудит, баталгаажуулалт, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улсын 7 дахь том фирм юм.

“Од Бүртгэл Аудит” ХХК нь 2016 онд Мүүрь Стевенс олон улсын сүлжээнд корресфонтент фирмээр элсэн орж, улмаар 2019 онд жинхэнэ гишүүн фирм болж нэрээ Мүүрь Аудит ХХК болгон өөрчилсөн. Мүүрь Аудит ХХК нь Монгол Улсын Сангийн сайдын олгосон 061-2008 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ Санхүүгийн Зохицуулах Хороонд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий аудитын фирмээр бүртгүүлсэн.

Мүүрь Глобал сүлжээний гишүүн фирмүүд нь дэлхийн өнцөг булан бүрд танд хүрч ажиллах боломжтой.

Тодруулбал:

- 112 улсад
- 266 фирм
- 609 оффистой
- 30,569 ажилтантай
- 3.06 тэрбум ам.долларын орлоготой байна.

Мүүрь Аудит ХХК болон Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль дүрэм, журмын хүрээнд 2022 оны 10 сарын 21-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж аудитын зүгээс хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн болно.



Мүүрь Аудит ХХК
 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
 1-р хороо Олимпын гудамж 7/3,
 Центрум төв 7 давхар, 701 тоот
 Утас: +976 7015 0003
 Факс: +976 7015 0003
 И-мэйл: info@moore-mongolia.mn
 www.moore-mongolia.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

Дүгнэлт

Бид, "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн (цаашид Сан гэх) 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Сангийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
 ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тод	Аудитлагдсан	Дахин
		2022.12.31 мян.төг	тайлагнасан 2021.12.31 мян.төг
Хүүгийн орлого	6	4,086,889	1,081,229
Ногдол ашгийн орлого	7	37,579	-
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлт, цэвэр	8	246,031	404,784
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр олз	9	1,314,470	-
Нийт орлого		5,684,969	1,486,013
Үүсгэн байгуулахтай холбоотой зардал	10	-	(857,496)
ХОМК-ийн үйлчилгээний зардал	10	(971,982)	(286,889)
Кастодианы үйлчилгээний зардал	10	(94,220)	(35,474)
Бусад зардал	10	(130,355)	(298,695)
Нийт зардал		(1,196,557)	(1,478,554)
Татвар төлөхийн өмнөх ашиг		4,488,412	7,459
Орлогын татварын зардал	11	(365,944)	(164,810)
Тайлант жилийн ашиг (алдагдал)		4,122,468	(157,351)
Бусад дэлгэрэнгүй орлого	12,17	971,456	-
Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)		5,093,924	(157,351)
Нэгж эрх эзэмшигчид ногдох үндсэн ашиг, төгрөг		82.45	-

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тод	Аудитлагдсан	Дахин
		2022.12.31	тайлагдсан
		Мян.төг	2021.12.31
			Мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө		10,198,723	-
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө		2,701,670	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		12,900,393	-
Эргэлтийн хөрөнгө			
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	12	-	4,864,033
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	12	18,340,871	44,847,923
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	12	21,390,508	-
Урьдчилж төлсөн төлбөр	13	64,216	-
Хүүгийн авлага	13	1,188,389	427,008
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	14	1,817,900	4,028
Нийт эргэлтийн хөрөнгө		42,801,884	50,142,992
НИЙТ ХӨРӨНГӨ		55,702,277	50,142,992
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Эздийн өмч			
Гаргасан нэгж эрх	15	50,000,000	50,000,000
Бусад нөөц	17	971,456	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	16	3,965,117	(157,351)
Нийт эздийн өмч		54,936,573	49,842,649
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад богино хугацаат өр төлбөр	18	535,833	200,955
Орлогын татварын өр	18	16,633	46,314
Нийт богино хугацаат өр төлбөр		552,466	247,269
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг	11	213,238	53,074
Нийт урт хугацаат өр төлбөр		213,238	53,074
Нийт өр төлбөр		765,704	300,343
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		55,702,277	50,142,992

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тод	Нэгж эрх		Хуримтлагдсан ашиг		Бусад нөөц		Нийт өмч	
		Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг	Мян.төг
2021.01.01-ний үлдэгдэл									
Гаргасан нэгж эрх	15	50,000,000	-	-	-	-	-	50,000,000	(157,351)
Тайлант жилийн ашиг (алдагдал)	17	-	-	(157,351)	-	-	-	-	-
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	16	-	-	-	-	-	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		50,000,000	-	(157,351)	-	-	-	(157,351)	49,842,649
2021.12.31-ний үлдэгдэл									
Гаргасан нэгж эрх	15	-	-	-	-	-	-	-	4,122,468
Тайлант жилийн ашиг (алдагдал)	17	-	-	4,122,468	-	-	-	971,456	971,456
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	16	-	-	-	-	-	-	971,456	971,456
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		50,000,000	-	4,122,468	-	-	971,456	5,093,924	54,936,573
2022.12.31-ний үлдэгдэл									



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тод	Аудитлагдсан	
		2022.12.31 мян.төг	Дахин тайлагнасан 2021.12.31 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		4,488,412	7,459
<i>Тохируулга:</i>			
Хүүгийн орлого	6	(4,086,889)	(1,081,229)
Ногдол ашгийн орлого	7	(37,579)	-
Валютын ханшийн зөрүүгийн бодит бус гарз олз	9	(1,149,866)	-
ААБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний (ашиг) алдагдал	8	(246,031)	(404,784)
		(1,031,953)	(1,478,554)
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>			
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт (өсөлт)	12	4,864,033	(4,459,249)
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт (өсөлт)	12	16,308,329	(44,847,923)
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт (өсөлт)	12	(22,746,869)	-
Урьдчилж төлсөн төлбөрийн бууралт (өсөлт)	13	(64,216)	-
Бусад өглөг дансны өсөлт/(бууралт)	18	334,878	200,955
Төлсөн орлогын татвар		(363,283)	(65,422)
Хүлээн авсан хүү		3,325,508	654,221
Хүлээн авсан ногдол ашиг		37,579	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		664,006	(49,995,972)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гаргасан нэгж эрх	23	-	50,000,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-	50,000,000
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)		664,006	4,028
Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз (гарз)	11	1,149,866	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,028	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,817,900	4,028

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



КАСТОДИАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Голомт банкны Кастодиан банкны хэлтсийн танилцуулга

2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн батлагдсан “Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль”, 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр шинээр батлагдсан “Хөрөнгө Оруулалтын Сангийн Тухай Хууль”-аар хөрөнгө оруулалтын сан болон түүнд үйлчилгээ үзүүлэгч талуудын үүрэг, харилцааг зохицуулах болсон билээ.

Голомт банк нь 2014 оны 08 сарын 27-ны өдөр хамгийн анхны кастодиан банкны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан. Кастодиан банк нь дараах зохицуулалттай үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлдэг. Үүнд:

- Кастодианы тусгай зөвшөөрөл
- Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг
- Төлбөрийн үйл ажиллагааг

Мөн 2017 оны 12 сарын 15-нд үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрлийг авснаар

- Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгалах
- Төлбөр тооцоог гүйцэтгэх
- Компанийн үйл ажиллагаа
- Нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх
- Нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг хөрөнгө оруулалтын менежментийн компаниас хараат бусаар гүйцэтгэх зэрэг хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагад сангийн талаар бие даасан мэдээлэл хүргүүлэх боломжтой болсон.

Үйл явдлын товчоон:

- 2014 Кастодианы тусгай зөвшөөрөл.
- 2015 Үйлчилгээний нээлтийг албан ёсоор хийв. Японы Nomura ICS системийг нэвтрүүлэв. Анхны харилцагчаа бүртгэв.
- 2016 МIТ системтэй бүрэн холболт хийв. Төвлөрсөн хадгаламжийн гишүүн болов.
- 2017 Глобал кастодианы шаардлагыг бүрэн хангаж саб-кастодиан болов. Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн зөвшөөрөл авсан.
- 2018 Олон улсын ISAE 3402 стандартыг хангасан.
- 2019 ICBC хамтын ажиллагааг эхлүүлэв. Гадаад төлбөр, тооцоо гүйцэтгэх болсон.
- 2020 Клирингийн Ерөнхий Гишүүн болов. Хамгийн анхны хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн.
- 2021 Хамгийн том хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн. КЕГ-ийн хүрээнд клирингийн болон төлбөрийн үйлчилгээ үзүүлж эхлэв.
- 2022 Хамтын нээлттэй ХОС-д үйлчилгээ үзүүлж эхлэв.

2021 оны 06 сарын 16-ны өдөр Голомт банк болон Мандал Ассет Менежмент ҮЦК нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын хүрээнд “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ” байгуулснаар Голомт Кастодиан банк нь “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС”-д оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэж хадгалах, үнэт цаас худалдаж авахтай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх, хүүгийн болон ногдол ашиг цуглуулах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолж олон нийтэд мэдээлэх зэрэг цогц үйлчилгээг үзүүлэх болсон.

Кастодианы үйл ажиллагааны жилийн тайлан

Голомт банкны Кастодиан үйлчилгээний хэлтэстэй байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-ний дагуу сангийн хөрөнгийг хадгалах, нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хийх, нэгж эрхийн цэвэр үнэлгээг гаргах зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Тухайлбал, Голомт банк нь 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС ХХК-ийн 55.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг хадгалж байна.

Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийн хувьд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д “хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан хөтөлнө” гэж заасан байдаг. “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС”-н хөрөнгийг хадгалдаг кастодианы хувиар дээр дурдсан гэрээний хүрээнд Голомт банк нь нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээг үзүүлж байна.

Сангийн нэгж эрх нь Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагддаг бөгөөд нэгж эрхийн төвлөрсөн бүртгэлийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТХТ) ХХК хөтөлдөг. Голомт банк нь ҮЦТХТ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр нэгж эрхийн өмчлөгчдийн мэдээлэл, тухайлсан бүртгэлийг өдөр тутам тулгалт хийж байна.

Нэгж эрхийн цэвэр үнэлгээг Голомт банкны Кастодиан үйлчилгээний хэлтсээс Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох дүрэм, журмын дагуу тооцоолон гаргаж, Монголын хөрөнгийн биржийн вэбсайтаар дамжуулан өдөр бүр мэдээлдэг. 2022 оны байдлаар Цэвэр хөрөнгийн үнэлгээний мэдээллийг 248 удаагийн тооцоолол хийгдэн сайтад мэдээлэгдсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сангийн зардлын бүтэц | сая төгрөгөөр

Зардлын төрөл	Дүн	Эзлэх хувь
Менежментийн үйлчилгээ	971.982	81.2%
Кастодианы үйлчилгээ	94.22	7.8%
Бусад	130.355	10.8%
Нийт	1,196,557	100%

2022 оны тайлант жилд сан нь 5,093,924,000 төгрөгийн ашигтай ажилласан нь аудитаар баталгаажсан болно. Тус онд нэгж эрх эзэмшигчид ногдох үндсэн ашиг нь 82.45 төгрөгийн ашигтай ажиллажээ.

Менежментийн үйлчилгээний зардал

2021 оны 06-р сарын 15-ны өдөр Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК нь Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сантай Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулснаар, хөрөнгө оруулалтын сангийн менежерээр томилогдон хөрөнгийг итгэмжлэн удирдаж эхэлсэн. ХОМК-ийн менежментийн үйлчилгээний жилийн шимтгэл нь сангийн нийт цэвэр хөрөнгийн 1 хувиар тооцогддог бөгөөд тус дүнг сар бүр тэнцүү хуваан төлдөг. Мөн өмнөх жилийн нийт ашгийн арван хувийг ХОМК-д урамшуулал болгон жилд нэг удаа төлдөг.

Кастодиан үйлчилгээний шимтгэл

Сангийн Кастодиан банкны үйлчилгээг Голомт банкны кастодиан үйлчилгээний хэлтэс гэрээний дагуу үзүүлж байна. 2022 онд нийт кастодианы үйлчилгээний шимтгэл нь 94.22 сая төгрөг байна.



**MANDAL
ASSET**

7575-9911

www.mandalasset.mn